

# Венчур Капиталын Хөрөнгө Оруулалтын Хөтөлбөр II (ВКХОХ II)

Байршил:  
Бүсийн

Төслийн дугаар:  
50118

Бизнесийн салбар:  
Мэдээлэл Харилцааны Технологи

Мэдэгдлийн төрөл:  
Хувийн

Байгаль орчны ангилал:  
FW

Захирлуудын зөвлөлд танилцуулах тов:  
2018 оны 5-р сарын 23

Төлөв байдал:  
**Судалгааны шатанд**

Англи хэл дээрх ТХББ-ийг нийтэд танилцуулсан огноо:  
2018 оны 4-р сарын 24

## Төслийн танилцуулга

ЕСБХБ нь өөрийн Венчур Капиталын Хөрөнгө Оруулалтын Хөтөлбөр II ("ВКХОХ II" нь ЕСБХБ-ны хэрэгжүүлж буй ВКХОХ-ийн үргэлжлэл бөгөөд 100 сая еврогийн хөрөнгө оруулалтын зориулалттай сан юм)-оор дамжуулан дүрмийн санд шууд хөрөнгө оруулах буюу шууд хөрөнгө оруулалттай холбоотой санхүүгийн арга хэрэгслүүд (хөрөнгө оруулалт тус бүр нь 15 сая евро хүртэлх хэмжээтэй)-ийг ашиглах замаар тус Банкны үйл ажиллагаа явуулдаг улс орнууд дахь эхлэлийн болон өсөлтийн шатандаа яваа технологийн компаниудад хөрөнгө оруулалт хийх зорилготой. Хөрөнгө оруулалт нь зах зээл дээрх венчур капиталын хөрөнгө оруулалтын дутуу орон зайг нөхөхөд тус дөхөм болох ёстой хязгаарлагдмал эх үүсвэр бүхий венчур капиталын сангуудаас үйлчилгээ авч чадахгүй байгаа инновацийн болон өсөлт өндөртэй жижиг ба дунд хэмжээний компаниудад хүрэхийг зорьж байна.

## Төслийн зорилго

i) ВКХОХ нь Банк тухайн Бүс нутагт мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлэх, технологийн экосистемийг хөгжүүлэх болон инновацийг дэмжих нөхцлийг хангаж; ii) Банк нь Бүс нутагт бий болсон венчур капиталын санхүүжилтийн дутагдмал байдлыг арилгахад ВКХОХ-өөр дамжуулан чухал үүрэг гүйцэтгэж; iii) ВКХОХ нь Банкинд өндөр эрсдэлтэй/өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтын боломжуудын багц бүрдүүлэх хандлагыг бий болгох бололцоог олгодог.

## Шилжилтийн нөлөөлөл

ВКХОХ II Сан нь саяхан байгуулагдсан, шинэлэг санаа бүхий технологийн өндөр дэвшилтэд суурилсан компаниудын хөгжлийг дэмжих, ЕСБХБ-ны үйл ажиллагаа явуулж буй Бүс нутагт эхлэлтийн шатандаа байгаа венчур капиталын хүртээмжийг сайжруулахыг дэмжихэд чиглэсэн Өрсөлдөх чадвартай бөгөөд Уян хатан шилжилтийн шинж чанарыг хангахад хувь нэмэр оруулах болно. ВКХОХ II Сан нь анхны ВКХОХ I Сангийн хүрсэн амжилтууд дээр тулгуурлах ба ЕСБХБ-ны Мэдлэгийн Эдийн Засгийн Санаачлага, ялангуяа 3 дугаар үрсгал – Технологид суурилсан жижиг компаниудын талаарх зарчимд нийцүүлэн тус Банкны үйл ажиллагаа явуулж буй Бүс нутагт мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлэх чиглэлд голлох дэмжлэг туслалцааг үзүүлнэ.

## Харилцагчийн мэдээлэл

Тухайн нөхцөл байдалд тохируулан авч үзнэ.

## ЕСБХБ-ны санхүүжилтийн дүн

100,000,000.00 евро

## Төслийн нийт өртөг

100,000,000.00 евро

## Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн хураангуй

Энэхүү Сан нь өөрөө Банкны 2014 оноос баримталж ирсэн Байгаль орчин болон Нийгмийн Бодлогын хүрээнд ангилагдаагүй болно. Гэхдээ дэд төслүүд тус тусдаа тухайн нөхцөл байдлаас хамаарч ангилагдах бөгөөд дэд төсөл ба харилцагч тус бүрийн онцлогт тохируулсан байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (“БОННБНУ”) болон Ногоон Эдийн Засгийн Шилжилт (“НЭЗШ” буюу англиар Green Economy Transition (“GET”))-ийн шалгалтанд хамрагдана. Дэд төслийн ангилалд үндэслэн зохих БОННБНУ нь дэд төсөл бүр Банкны Гүйцэтгэлийн Шаардлага (“ГШ”)-д нийцэх бүтэцтэй байна гэдгийг баталгаажуулна.

## Техникийн хамтын ажиллагаа

Байхгүй.

## Компанийн холбоо барих мэдээлэл

Бахром Ибрагимов  
02073386000

## Бизнесийн боломжууд

Бизнесийн боломжууд болон худалдан авах ажиллагааны талаар харилцагч компанитай холбогдоно уу.

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээллийг [EBRD Procurement](#) вэб хуудаснаас авна уу:

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: [procurement@ebrd.com](mailto:procurement@ebrd.com)

## Ерөнхий лавлагаа, үйл ажиллагаатай холбоотой асуулт

ЕСБХБ-ны төслүүдийн худалдан авах ажиллагаанаас бусад асуудлаар лавлагаа мэдээлэл авах:

Утас: +44 20 7338 7168;

Цахим шуудан: [projectenquiries@ebrd.com](mailto:projectenquiries@ebrd.com)

## Олон нийтийн мэдээллийн бодлого (ОНМБ)

Олон нийтийн мэдээллийн бодлого (“ОНМБ”) нь ЕСБХБ өөрийн стратеги, бодлого, үйл ажиллагааны талаархи олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үүднээс мэдээллийг хэрхэн ил болгох, оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөж ажиллах журмыг тодорхойлдог. Төрийн хэвшлийн захирлуудын зөвлөлийн тайлан илтгэл авах хүсэлтийг хэрхэн гаргах талаарх мэдээллийг доорх холбоосоор ОНМБ-ын вэб хуудаснаас авна уу.

[ОНМБ-ын бичвэр](#)

## Төслийн гомдлын газар (ТГГ)

Төслийн Гомдлын Газар (“ТГГ”) нь ЕСБХБ-ны эгэх хариуцлагын механизм юм. Энэ нь ЕСБХБ-ны санхүүжилттэй аливаа төсөл байгаль орчинд буюу нийгэмд хор хохирол учруулсан эсвэл учруулж болзошгүй гэж үзсэн хувь хүн болон байгууллагын зүгээс гаргасан гомдлыг хараат бусаар хянан үзэх боломж олгодог.

Гомдол хэрхэн гаргах талаар мэдээлэл авахыг хүсвэл ТГГ-ын [Project Complaint Mechanism](#) вэб хуудсанд хандана уу. ТГГ-ын ажилтан ([pcm@ebrd.com](mailto:pcm@ebrd.com)) гомдол гаргах, гомдлыг бүртгэх ба гомдлын шаардлагын шалгуурт хэрхэн нийцүүлэх тухай асуудлаар [ТГГ-ын Үйл ажиллагааны журам \(PCM Rules of Procedure\)](#)-ын дагуу таны асуултанд хариулахад бэлэн байна.